



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2020.4.28

Төрийн аудитын байгууллагын зүгээс хийх аудит, аудитын төлөвлөлт, Ерөнхий аудитор Улсын Их Хурал болон Засгийн газартай харилцах, төрийн аудитын хууль зүйн баталгаа, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн асуудлаарх санал

No	Холбогдох зүйл, заалт болон санал болгож буй өөрчлөлт	Үндэслэл
9 дүгээр зүйл. Гүйцэтгэлийн аудит		
1	Одоо үйлчилж буй Төрийн аудитын хуулийн 19.1-т “Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамрагдах аливаа байгууллага, хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийж болно.” гэснийг шинэчилсэн найруулгад 9.1-р зүйл болгон нэмж оруулах.	Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд санхүүгийн аудитаас гадна улс, орон нутгийн төсвийн санхүүжилттэй байгууллагын бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэх болон тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналт үр нөлөөтэй эсэхэд дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх гүйцэтгэлийн аудит чухал үүрэгтэй. Иймд Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамрагдах аливаа байгууллага, хөтөлбөрт гүйцэтгэлийн аудит хийх эрхтэй байх шаардлагатай гэж үзэж байна.
2	9.4 дэх зүйл болгон нэмэх: “Дараах гүйцэтгэлийн аудитыг хийнэ: - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд - Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд - Засгийн газрын өрийн удирдлагын дүнд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд -Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд	Хуулийн төслийн 8.1-т “...улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсвийн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ” гэж заасан байгаа нь эдгээр баримт бичгийн аудит нь аудитын жилийн төлөвлөгөөнд заавал тусгагдсан байх нөхцөл бүрдэж байна гэж үзэж байна. Үүнтэй адилаар Монгол Улсын хөгжил, төсөв, санхүү, өрийн бодлогын чиглэлээрх бидний санал болгож буй нэр дурдсан үндсэн баримт бичгүүдийн төлөвлөлт, гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудитыг хийхээр хуульд тусгаснаар эдгээр нь аудитын жилийн төлөвлөгөөнд заавал тусгагдсан байх нөхцөл бүрдэх юм.

No	Холбогдох зүйл, заалт болон санал болгож буй өөрчлөлт	Үндэслэл
	<p>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт - Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд”</p> <p>- Дээрх аудитиудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд”.</p>	<p>Төрийн аудитаас шалгадагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдтэй танилцахад өмнө өгсөн зөвлөмж давтагдах хандлагатай байгаа нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах байдал хангалтгүй байгааг харуулж байна хэмээн үзэж байна. Иймд бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэх болон тогтолцоо, үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний хэмжилт, дотоод хяналтыг сайжруулахын тулд аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж, түүний хэрэгжилтийг дээшлүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай юм.</p>
10 дугаар зүйл. Нийцлийн аудит		
3	<p>“Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамрагдах аливаа байгууллага, хөтөлбөрт нийцлийн аудит хийж болно.” гэж 10.1-р зүйл болгон нэмж оруулах</p>	<p>Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаас гадна улс, орон нутгийн төсвийн санхүүжилттэй байгууллага үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж буй эсэх, мөрдөж буй төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын нийцэлд хийх нийцлийн аудит чухал үүрэгтэй. Иймд Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамрагдах аливаа байгууллага, хөтөлбөрт болон хууль тогтоомжид нийцлийн аудит хийх эрхтэй байх шаардлагатай гэж үзэж байна.</p>
4	<p>10.5 дахь зүйл болгон нэмэх: “Дараах нийцлийн аудитыг хийнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд” 	<p>Хуулийн 8.1-т “...улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсвийн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ” гэж заасан байгаа нь эдгээр баримт бичгийн аудит нь аудитын жилийн төлөвлөгөөнд заавал тусгагдсан байх нөхцөл бүрдэж байна гэж үзэж байна. Үүнтэй адилаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт болон төсвийн төлөвлөлт, зарцуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээрх нэр дурдсан асуудлаар нийцлийн аудитыг хийхээр хуульд тусгаснаар эдгээр нь аудитын жилийн төлөвлөгөөнд заавал тусгагдсан байх нөхцөл бүрдэх юм. Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангаснаар төрийн бодлого, төсөв,</p>

No	Холбогдох зүйл, заалт болон санал болгож буй өөрчлөлт	Үндэслэл
		санхүүгийн удирдлагад иргэд мэдээлэлтэй оролцох боломжийг олгоход чухал ач холбогдолтой юм.
11 дүгээр зүйл. Аудитын төлөвлөлт		
5	11.3.“Энэ хуулийн 11.2.1-д зааснаас бусад аудитын сэдвийг батлахдаа дараах хүчин зүйлд үндэслэнэ:” хэсэгт 11.3.4. “төрийн аудитын байгууллагын цахим хуудсаар аудитын сэдэвт санал авах хугацаанд иргэд, олон нийтээс ирүүлсэн санал” гэж нэмэх	Төрийн хяналтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс төрийн аудитын байгууллага дараа оны аудитын сэдэвт иргэдээс цахим хуудсаараа санал авдаг. Иймд аудитын сэдвийг батлахдаа иргэдээс цахимаар авсан саналыг харгалзан үзэх талаар хуульд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.
33 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах		
6	33.2. “... танилцуулгыг сонсож болно.” гэснийг “...танилцуулгыг сонсоно” гэж өөрчлөх.	Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлт чухал тул энэ талаарх Монгол Улсын Ерөнхий аудиторын танилцуулгыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо заавал сонсохоор хуульд тусгах нь зүйтэй хэмээн үзэж байна.
7	33.3-т нэмэх: “Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо төрийн аудитын байгууллагын аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр холбогдох албан тушаалтны боловсруулсан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэнэ.”	Төрийн аудитаас шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдтэй танилцахад өмнө өгсөн зөвлөмж давтагдах хандлагатай байгаа нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахгүй байх явдал их байгааг харуулж байна. Иймд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хэлэлцэж байх нь аудитын зөвлөмжийн биелэлтийг дээшлүүлэхэд чухал юм.
34 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор Засгийн газартай харилцах		
8	34.3. “Засгийн газар төрийн аудитын байгууллагаас Засгийн газрын харьяа захиргааны байгууллагад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллан, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэсэн зүйл нэмэх	Төрийн аудитаас шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдтэй танилцахад өмнө өгсөн зөвлөмж давтагдах хандлагатай байгаа нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахгүй байх явдал их байгааг харуулж байна. Иймд аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаж байх нь зөвлөмжийн хэрэгжилтийг дээшлүүлснээр төрийн бодлого, төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулахад чухал юм.

No	Холбогдох зүйл, заалт болон санал болгож буй өөрчлөлт	Үндэслэл
37 дугаар зүйл. Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах		
9	37.2-т “Төрийн аудитын байгууллагаас хийсэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг жилд нэг удаа өөрийн цахим хуудаст нийтэд нээлттэй, ил тод байршуулна.” гэж нэмэх	Төрийн аудитын байгууллагаас аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг нийтэд нээлттэй, ил тод байршуулснаар улсын бодлого, санхүү, төсвийн хяналтад иргэний нийгмийн оролцоог дээшлүүлснээр аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулахад ач холбогдолтой.
38 дугаар зүйл. Хууль зүйн баталгаа		
10	38.2-т “Төрийн аудитын байгууллага болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.” гэснээс “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга” гэдгийг хасах	Төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд төрийн аудитын байгууллагын хараат бус байдал чухал тул Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга хяналт тавих, үүрэг даалгавар өгөх нь төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг бууруулах юм.
42 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага		
11	42.1-т нэмэх: “Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцно.”	Төрийн аудитаас шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдтэй танилцахад өмнө өгсөн зөвлөмж давтагдах хандлагатай байгаа нь аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахгүй байх явдал их байгааг харуулж байна. Иймд аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцсоноор аудитын зөвлөмжийн хэрэгжилт дээшлэх, төрийн бодлого, төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулахад чухал юм.

000000000000